ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ТӨВ АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ 2014 ОН

Танилцуулгын агуулга

- Нэр томъёоны тайлбар
- Оршил
- Танилцуулгын зорилго
- Танилцуулгын аргачлал
- ХАЗ-н үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал
- Хүн амын өсөлт
- Төрөлт, нас баралт
- Судалгаа
- Дүгнэлт, санал

I. Нэр томъёоны тайлбар, тодорхойлолт

Суурин хүн ам=тухайн сум, дүүргийн (баг, хорооны) нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүн ам+оны эцэст сум, дүүргийн (баг, хорооны) нутаг дэвсгэрт байхгүй боловч 6 сарын дотор орон нутагтаа эргэж ирэх түр эзгүй хүн. Оны эхний хүн ам+(төрсөн хүүхдийн тоо-нас барсан хүний тоо)+(шилжиж ирсэн хүний тоо-шилжиж явсан хүний тоо)=оны эцсийн хүн амын тоо

Өрх-ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ.

Нэг өрхөд ногдох хүний тоо. Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тооллогдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.

Хүн амын байршил: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулинд: **Хот**-гэдэгт 15000-аас доошгүй оршин суугчидтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг;

Тосгон гэдэгт: 500-15000 хүртэл оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, тээвэр, аялал жуучлал, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн өөрийн удирдлага бүхий суурин газрыг ;

Хүйсийн харьцаа: Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

Хүн ам зүйн ачаалал: Хүн ам зүйн ачаалал гэсэн үзүүлэлт нь 0-14 насны болон 65, түүнээс дээш настай хүн амын тоог 15-64 насны хүн амын тоонд харьцуулсан харьцааг илэрхийлдэг

Б. Хүн амын ердийн хөдөлгөөн:

Төрөлтийн ерөнхий коэффициент. Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж тооцдог.

Төрөлтийн тусгай коэффициент: Төрөх насны буюу (15-49 насны) 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент: Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцааг хэлнэ.

Нас баралтын ерөнхий коэффициент: Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Насны бүлэг дэх нас баралтын коэффициент:Тухайн насны бүлэгт нас барсан

хүний тоог мөн насны бүлгийн хүн амд харьцуулсан харьцаа юм.

Нялхасын нас баралтын коэффициент: Нэг хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулсан харьцаагаар илэрхийлдэг үзүүлэлт юм.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг "Батлуулсан гэр бүлтэй" буюу гэр бүлтэй гэнэ.

Шилжилт хөдөлгөөн: "Иргэний бүртгэлийн тухай" Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан журманд "Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ"

26 дугаар зүйлд "Иргэнийг аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар эрхэлнэ. Иргэнийг аймаг, нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, мэдээлэх ажлыг хариуцна" гэж тус тус заажээ.

Бүтэн өнчин хүүхэд-гэдэгт эцэг, эх нь хоёул нас барсан, хагас өнчин хүүхэд гэдэгт эцэг, эхийн аль нэг нь нас барсан хүүхдийг бүртгэнэ.

Бутач хүүхэд болон гэр бүл салалтаас болж, эцэг, эхийнхээ аль нэгэнтэй нь амьдарч байгаа эцэг, эх нь энх тунх байгаа хүүхдүүдийг өнчин гэж үзэхгүй юм.

"Хүүхдийн эрхийг хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ""Хүүхдийн эрхийг хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1-д "Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ"

16 хүртэл настай хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоо-эцэг эх, хамаатан садангийн алинтай нь хамт амьдардгийг харгалзахгүйгээр бүгдийг хамруулна (эрэгтэй, эмэгтэй)

Өрх толгойлсон хүний тоо: Гэр бүлгүй өрхийн тэргүүлэгчдийн тоог хүйсээр ялгаж гаргана.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн-тоонд хүүхэдтэй эсэхийг үл харгалзан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг;

Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд гэр бүлгүй, өрхөө толгойлон амьдарч байгаа эрэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг үл харгалзан хамруулна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" гэж ойлгоно.”

Энэ хуулийн 4 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай” Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлд “…Хөгжлийн бэрхшээлтэйг тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно…”

Өрхийн зарим үзүүлэлт: Нийт өрхөөс 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүдийг тусгайлан гаргасан. Мөн өндөр настай ганц бие амьдарч байгаа 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэйг тусгайлан, Нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэг тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоог гаргахдаа эрэгтэй 60 ба түүнээс дээш насныхныг, эмэгтэйг 55 ба түүнээс дээш насныхныг хамруулан гаргасан.

Эдийн засгийн бүсэд:

Төвийн бүс - Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Сэргэлэн, Зуунмод .

Хойд бүс - Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр.

Зүүн бүс - Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ.

Баруун бүс - Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант.

Оршил

Төв аймаг засаг захиргааны хувьд 1923-1931 онд Богдхан уулын аймаг гэж нэрлэгдэж 82 сум,1227 арван гэрийн захиргаатай байжээ.

1932 оноос Төв аймаг гэж нэрлэгдсэн, энэ онд 34 сум 312 багтай байсан бол 1956 онд 26 сум хороод, 207 баг байсан. Үүнд: САА 4, ХАА нэгдэл 35, өвс хадах морин станц 7 харъяалагдаж байсан.

1956 онд Сэлэнгэ аймгийг нэгтгэн Төв аймгийг 33 сум, 248 багтай болгон цомтгох арга хэмжээ авсан байна. Үүгээр Баянцагаан, Баянчандмань, Лүн, Сэргэлэн, Угтаалцайдам, Өнжүүл, Баян, Эрдэнэ, Эрдэнэсант, Дархан зэрэг сумд, Зүүнхараа, Сүхбаатар хотын захиргаа нийлээд бүгд 12 сум, хот, хороо 107 багтай болсон.

1959 онд дахин зохион байгуулалт хийж өөрчилсөнөөр 23 сум 1 хот, 3 хороотой болж 1978 оныг хүртэл Их хайрханы хороо захиргаа, Баянбараат, Тариат сумд татан буугдаж, Цээл, Баянхангай, Сүмбэр, Аргалант зэрэг сумд шинээр байгуулагдсан ба одоо 27 сум, 97 багтай байна.

Хүн ам зүйн судалгаанд хүн амын нас хүйсийг судлах нь хүн ам, нийгэм эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлийг нийгэм эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад ач холбогдолтой. Хүн амын нас хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой байдаг учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас, хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээгээр хүн амын түүхэн хөгжил хувьслыг болон ирээдүйн хэтийн төлөвийг тодорхойлдог.

Танилцуулгын зорилго:

Энэхүү танилцуулгад Төв аймгийн 2012-2014 оны хүн амын тоо, өсөлтийн өөрчлөлт, нас хүйсийн бүтэц, хүн амын төрөлт, дундаж наслалт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн гэх зэрэг хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрт гарсан өөрчлөлт болон хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүдийн талаархи санал дүгнэлт гаргахыг зорилоо.

Танилцуулгын аргачлал:

Танилцуулгыг гаргахын тулд 2012-2014 оны Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний тайлан, хүн амын шилжилт хөдөлгөөний тайлангуудын үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Танилцуулгыг боловсруулсан арга зүй:

Статистикийн албан ёсны мэдээ, тайланд тулгуурлан холбогдох үзүүлэлтийг тооцож, өмнөх онуудтай нь харьцуулан дүгнэж, статистикийн хүснэгт, зургаар харуулан хийлээ.

Хамруулсан хугацаа:

Үзүүлэлтүүдийг ихэвчлэн 2012-2014 оноор, зарим шаардлагатай үзүүлэлтийг 2000-2014 оны байдлаар авч хийлээ.

- **Хүн ам зүйн байдал:**
- Хүн амын тоо, түүний өсөлт байршилт:
- 2014 оны жилийн эцсийн байдлаар манай аймгийн суурин хүн ам 90.04 мянгад хүрч, 2013 оноос 1.84%-иар, 2012 оноос 2.94%-иар өслөө. Сүүлийн 3 жилд дунджаар 1.1%-иар өсчээ.

Хүн амын тоо, нас хүйс, байршлаар

Он	Нийт хүн ам	Үүнээс: хүйсээр		Бүгдээс			
				хот, суурин, сумын төв		хөдөөд	
		Эрэгтэй	Эмэгтэй	тоо	хувийн жин	тоо	хувийн жин
2012	87410	44556	42854	48143	55.08	39267	44.92
2013	88399	45046	43353	48052	54.36	40347	45.64
2014	90049	46136	43913	49880	55.39	40169	44.61

Зураг 1. Хүн амын байршлыг сумдаар харуулбал:

Сумын хүн амыг газрын зургаар

	Интервал - хүнээр	Сумын тоо
	1254-1778	7
	1779-2086	7
	2087-4099	7
	4100-16094	6



Зураг 2.



Нийт хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн хувийн жин сүүлийн жилд 0.28 пунктээр буурчээ. (зураг3)



Аймгийн нийт хүн амд 0-34 насны хүүхэд залуучуудын эзлэх хувийн жин сүүлийн 3 жилд 2.15 пунктээр буурч байгаа нь төрөлт бага байгаагаас насны бүлэг ахих тутам нас баралтын нөлөөгөөр тухайн насны хүн ам буурч байгаагаар тайлбарлана.

Зураг 4.



Нийт хүн амын 55.39 хувь буюу 49.88 мянга нь төв суурин газар, 44.61 хувь буюу 40.16 мянга нь хөдөө амьдарчээ.

Төв суурин газарт эрүүл мэнд, боловсрол болон ахуйн үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр олох газар болж байгаагаас хүмүүс ихээр татагдаж байна.

Зураг 5.

Сүүлийн жилүүдэд дээрхи шалтгааны улмаас хөдөө суурьшигчдийн тоо буурч, төв суурин газар руу шилжигсэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа 2014 онд хөдөөнөөс төв суурин газар луу шилжин суурьшигчид 1.03%-иар өслөө.

Зураг 6.



Зураг 7.



Аймгийн хүн амын дундаж өсөлт 2012 онд 0.99 хувиар буурч, 2013 онд 1.12% , 2014 онд -1.84%-иар өслөө.

2.Хүн амын, нас хүйсийн бүтэц

Хүснэгт2

Он	Нийт хүн ам	үүнээс:					
		0 -15 насны	%	Хөдөлмөрийн насны	%	Тэтгэврийн насны	%
2014	90049	26499	29.43	53074	58.94	10476	11.63
2013	88399	26031	29.45	52478	59.36	9890	11.19
2012	87410	25355	29.01	52696	60.29	9359	10.71

Нийт суурин хүн амын 29.43 хувийг 0-15 насны хүүхэд, 58.94 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 11.63 хувийг тэтгэврийн насны хүн ам эзэлжээ. Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2014 онд өмнөх оноос 0.02 пунктээр, хөдөлмөрийн насны хүн ам 0.42 пунктээр буурч, тэтгэврийн насны хүн ам 0.44 пунктээр өсчээ.

Хүн амын насыг 5 насны интервальтайгаар, хүйсээр, ингэхдээ хүн амын нас,

хүйсийг зурах сонгодог зарчмын дагуу эрэгтэйчүүдийг зүүн талд нь, эмэгтэйчүүдийг баруун талд нь насыг дооройоос дээш өсгөх байдлаар дүрслэн харуулсан болно. Хүн амын тоо хэмжээний өсөлтийг жилээр харьцуулж харах, түүнчлэн нас, хүйсийн бүтэц нэг хэвийн биш байгаа эсэхийг хараад шууд мэдэхэд ойлгомжтой, тохиромжтой байх үүднээс суваргыг бодит тоогоор зурсан. Хүн амын нас хүйсийн суваргаас харахад бүтэц хэвийн, 2013 онд ихэнх насны бүлэг дэх эрэгтэйчүүдийн тоо өссөн, ялангуяа идэр насны буюу 35-39 насны эрчүүд өссөн харагдлаа.

Хүйсийн харьцаа:

100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь сүүлийн жилүүдэд аажим өсч эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсч байгаа нь харагдлаа. 2014 онд 100 эмэгтэй тутамд 105 эрэгтэй ногдлоо. Энэ нь сүүлийн жилүүдэд шилжих хөдөлгөөний эерэг урсгалд эрэгтэйчүүд, сөрөг урсгалд эмэгтэйчүүд илүү оролцож байгаагаас хүйсийн харьцаа өндөр гарчээ. Ер нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хүйсийн харьцаа өндөртэй аймгуудын тоонд орлоо.

Зураг 9. Хүйсийн харьцаа 2008-2013



Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэдэг.

2012, 2013, 2014 онд аймгийн хөдөлмөрийн насны 100 хүнд 28 хүүхэд, 5 тэтгэврийн насны хүн ногдлоо. (зураг 3)

Зураг 10. Хүн ам зүйн ачаалал, 2012, 2013, 2014 он



Хүн амын дундаж наслалт:

Дундаж наслалт бол таамаглах хэмжигдэхүүн бөгөөд хүн амын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох гол үзүүлэлт юм. Дундаж наслалт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициентыг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогдох үзүүлэлт юм. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь дундаж наслалтын ерөнхий хэмжигдэхүүн болдог.

Хүснэгт-дундаж наслалт

	2007	2009	2011	2013
Дундаж наслалт	68.26	69.76	70.28	71.46

Аймгийн хүн амын дундаж наслалт 2013 онд 71.46 байна. Дундаж наслалтын өсөлт, бууралт нь хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс шалтгаална.

Өрх

Төв аймгийн өрхийн тоо 2014 онд 28063 буюу өмнөх оноосоо 2.81%-иар өсчээ.

Өрхийн тоо, байршлаар, нэг өрхөд ноогдох дундаж ам бүл

Он	2014 оны	үүнээс				Өрхийн дундаж ам бүл
		Хот суурин, сумын төв		Хөдөөд		
		тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	
2014	28063	15286	54.47	12777	45.53	3.26
2013	27277	14719	53.96	12558	46.03	3.24
2012	26779	14530	54.26	12249	45.74	3.28

2000 оны байдлаар нэг өрхөд ногдох дундаж хүн ам дунджаар 4.2, 2009 онд 3.34 байсан бол 2010-2014 онд 3.3-3.26 болж буурсан нь төрөлт болон шилжилт хөдөлгөөнтэй шууд хамааралтайг харууллаа.

Зураг 11. Нэг өрхөд ногдох дундаж ам бүлийн тоо 2009-2014 оноор



Харин 2009 оноос хойш төв суурин газарт амьдрах өрхийн хувийн жин өсөж, хөдөө амьдрах өрхийн хувийн жин буурч байгаа нь эрүүл мэнд, боловсрол болон ахуйн үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр олох газар болж байгаагаас хүмүүс ихээр татагдаж байна.

Зураг 12.

Зураг 13.

Өрхийн ам бүлийн тоо төв суурин газар, хөдөөд ялгаатай байгаа боловч,8-аас дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд бараг адил байна. Нийт өрхөд 8 аас дээш ам бүлтэй өрхийн хувийн жин 2014 онд 2013 оноос 1.12 пунктээр өслөө. Зураг 14.



Хүн амын төрөлт Төрөлтийн түвшинг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 1000 хүнд ногдох төрөлт 2012 онд 18.0, 2013 онд 26.93, 2014 онд 25.23 болж ойролцоогоор 2 хүнээр буурлаа.

Хүн амын ердийн хөдөлгөөний тайланг ашиглан хийсэн зэрэгцүүлсэн судалгаа. (Төрөлт)

	хэмжих нэгж	2012 он			2013 он			2014 он		
		төр-сөн хүүхэд бүгд	үүнээс		төр-сөн хүүхэд бүгд	үүнээс		төр-сөн хүүхэд бүгд	үүнээс	
			Хот-од	Хөд-өөд		Хот-од	Хөд-өөд		Хот-од	Хөд-өөд
1. Төрсөн хүүхдийн тоо	тоо	1758	373	1385	2368	456	1912	2252	421	1831
үүнээс 15-19 настай эхээс	-"-	99	165	541	161	22	139	110	18	92
. 20-24 настай эхээс	-"-	569	110	451	779	152	627	649	118	531
. 25-29 -"-	-"-	440	58	248	687	141	546	642	136	506
. 30-34 -"-	-"-	262	31	115	453	84	369	467	80	387
. 35-39 -"-	-"-	121	8	27	229	45	184	303	57	246
. 40-44 -"-	-"-	25	1	3	55	12	43	78	12	66
. 45-49 -"-	-"-	5			3		3	3		3
. 50 ба дээш	-"-				1		1			
2. Төрсөн эхээс эмнэлэгт төрсөн	-"-	1758	373	1385	2368	456	1912	2368	456	1912
. Эмнэлэгт төрөлтийн хувь	хувь	100	100	100	100	100	100	105	108	104
3. Төрөлтийн ерөнхий коэффицент										
. буюу 1000 хүн амд ногдох	тоо	**18**	20	17	**27**	30	26	**25**	27	25
төрөлт:үүнээс 15-19 настай эх	-"-	8	7	8	21	19	21	15	16	15
20-24 настай эхэд	-"-	64	77	62	83	87	86	73	72	77
25-29 -"-	-"-	64	63	65	89	90	87	81	83	79
30-34 -"-	-"-	37	38	37	65	69	65	67	63	68
35-39 -"-	-"-	20	27	18	36	42	35	47	52	45
40-44 -"-	-"-	4	6	3	9	12	9	13	12	13
45-49 -"-	-"-	2		2	1		1	1		1
50 ба дээш	-"-				0		0			
4.Төрөх насны эмэгтэйчүүдийн	-"-									
(15-49)Коэфф-т (1000 эмэгтэйд)	коэф	**61**	63	61	**55**	58	55	**52**	53	52
үүнээс :15-19 насны эхэд	-"-	16	13	17	43	39	44	30	33	29
20-24 -"-	-"-	127	142	124	177	172	179	157	143	161
25-29 -"-	-"-	129	117	131	199	184	204	174	172	174
30-34 -"-	-"-	73	73	74	140	138	140	144	127	149
35-39 -"-	-"-	39	51	36	76	83	74	99	104	98
40-44 -"-	-"-	8	11	7	19	21	19	27	21	28
45-49 -"-	-"-	3		4	1		1	1		1
5. Төрсөн эхчүүд бүгд	тоо	1984	429	1555	2352	454	1898	2230	416	1814
6. Боловсролын байдлаар:	-"-									
а. Дипломын дээд	-"-	412	153	259	641	210	431	610	210	400
г.Тусгай дунд	-"-	76	32	44	71	6	65	60	12	48
в.Техник мэргэж-н дунд	-"-	79	25	54	79	2	77	41	3	38
д. Бүрэн дунд	-"-	844	192	652	959	201	758	987	176	811
е. Бүрэн бус дунд	-"-	471	22	449	451	32	419	421	15	406
ё. Бага боловсролтой	-"-	83	3	80	126	2	124	101		101
з. Боловсролгүй	-"-	19	2	17	25	1	24	10		10
7. Гэр бүлийн : Гэр бүлгүй	-"-	295	38	257	380	91	289	265	65	200
. байдал : Гэр бүлтэй	-"-	1689	391	1298	633	139	494	688	136	552
: үүнээс Батал-	-"-									
: гаатай	-"-	1420	277	1143	1339	224	1115	1277	215	1062

Төрөлтийн тусгай коэффициентоор нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг. Эндээс харахад манай аймгийн нөхөн үржихүйн насны /15-49/ 1000 эмэгтэй тутамд ногдож буй төрсөн хүүхдийн тоо 2014 онд 52 болж 2013 оноос 5.46 хувиар буурлаа.

Төрөх насны эмэгтэйчүүдийн насны бүтцийг зургаар харуулбал: Зураг 14.



Зураг 15. 1000 хүнд ногдох төрөлтийн ерөнхий коффициент



Зураг 16.



Нас баралт

Нас баралтын ерөнхий коэффициентыг сүүлийн 3 жилээр харууллаа. 1000 хүнд ногдох нас баралт манай аймгийн хувьд 2014 онд 6.9 боллоо.

Хүн амын ердийн хөдөлгөөний тайланг ашиглан хийсэн зэрэгцүүлсэн судалгаа. (Нас баралт)

	хэм-жих нэгж	2012 он					2013 он					2014 он				
		Нас бар-сан бүгд	үүнээс		1000 хүнд ногдох нас баралтын Ер ба тусгай Коэфф-т	Нас барал-тын дүнд бүлгүүд-ийн хувь	Нас бар-сан бүгд	үүнээс		1000 хүнд ногдох нас баралтын Ер ба тусгай Коэфф-т	Нас барал-тын дүнд бүлгүүд-ийн хувь	Нас бар-сан бүгд	үүнээс		1000 хүнд ногдох нас баралтын Ер ба тусгай Коэфф-т	Нас барал-тын дүнд бүлгүүд-ийн хувь
			Эрэг-тэй	Эмэг-тэй				Эрэг-тэй	Эмэг-тэй				Эрэг-тэй	Эмэг-тэй		
1.Нас барсан хүн бүгд	тоо	**671**	422	249	7.6	100.0	**555**	352	203	6.3	100.0	**618**	384	234	6.9	100.0
. 0- 4 насны дүн	-"-	**30**	18	12	4.3	4.5	**15**	8	7	1.8	2.7	**24**	8	16	2.3	3.9
. 5- 9 насны дүн	-"-	**6**	5	1	0.8	0.9	**5**	4	1	0.7	0.9	**8**	5	3	1.0	1.3
. 10-14 насны дүн	-"-	**4**	3	1	0.5	0.6	**4**	1	3	0.5	0.7	**5**	2	3	0.7	0.8
. 15-19 насны дүн	-"-	**8**	8		0.7	1.2	**4**	3	1	0.4	0.7	**6**	4	2	0.8	1.0
. 20-24 насны дүн	-"-	**17**	15	2	1.8	2.5	**11**	9	2	1.2	2.0	**10**	7	3	1.2	1.6
. 25-29 насны дүн	-"-	**10**	7	3	1.3	1.5	**13**	12	1	1.6	2.3	**20**	15	5	2.5	3.2
. 30-34 насны дүн	-"-	**14**	11	3	2.0	2.1	**19**	15	4	2.7	3.4	**10**	9	1	1.4	1.6
. 35-39 насны дүн	-"-	**27**	17	10	4.4	4.0	**27**	20	7	4.3	4.9	**33**	27	6	5.1	5.3
. 40-44 насны дүн	-"-	**32**	25	7	5.6	4.8	**27**	21	6	4.7	4.9	**27**	13	14	4.6	4.4
. 45-49 насны дүн	-"-	**41**	30	11	8.1	6.1	**31**	24	7	5.9	5.6	**38**	29	9	6.9	6.1
. 50-54 насны дүн	-"-	**68**	54	14	18.2	10.1	**51**	34	17	11.8	9.2	**55**	38	17	10.9	8.9
. 55-59 насны дүн	-"-	**71**	45	26	28.9	10.6	**52**	39	13	17.6	9.4	**52**	42	10	14.0	8.4
. 60-64 насны дүн	-"-	**55**	33	22	29.9	8.2	**63**	47	16	30.9	11.4	**47**	35	12	20.4	7.6
. 65-69 насны дүн	-"-	**61**	36	25	35.9	9.1	**39**	29	10	25.0	7.0	**63**	30	33	44.9	10.2
70-74 насны дүн	-"-	**74**	38	36	58.6	11.0	**47**	26	21	37.7	8.5	**68**	42	26	54.1	11.0
. 75 -79 насны дүн	-"-	**62**	33	29	83.2	9.2	**45**	25	20	63.0	8.1	**54**	31	23	71.6	8.7
80-84 насны дүн	-"-	**45**	23	22	133.9	6.7	**56**	18	38	142.0	10.1	**45**	27	18	93.9	7.3
85 - 89 насны дүн	-"-	**24**	10	14	122.4	4.0	**24**	9	15	133.3	4.3	**21**	11	10	123.5	3.4
90 - 94 насны дүн		**16**	8	8	202.5	2.4	**13**	1	12	181.8	2.3	**5**	3	2	71.4	0.8
95 - 99 насны дүн	-"-	**6**	3	3	279.1	0.9	**7**	5	2	350.0	1.3	**7**	3	4	318.2	1.1
100 ба дээш насны дүн								2					3			
II. Боловсролоор: үүнээс		**671**	422	249		100.0	**555**	352	203		100.0	**618**	384	234		100.0
1. Дээд	-"-	**38**	30	8		5.7	**40**	30	10	x	7.2	**50**	32	18	x	8.1
2.Тусгай мэргэжлийн дунд		**34**	21	13		5.1	**47**	32	15	x	8.5	**38**	24	14	x	6.1
3.Мэргэжлийн, анхан шатны	-"-	**44**	29	15		6.6	**17**	9	8	x	3.1	**25**	19	6	x	4.0
4. Бүрэн дунд	-"-	**116**	76	40		17.3	**141**	86	55	x	25.4	**171**	111	60	x	27.7
5. Суурь боловсролтой	-"-	**191**	127	64		28.5	**107**	74	33	x	19.3	**116**	72	44	x	18.8
6. Бага боловсролтой	-"-	**188**	98	90		28.0	**159**	95	64	x	28.6	**176**	101	75	x	28.5
7. Боловсролгүй	-"-	**60**	41	19		8.9	**44**	26	18	x	7.9	**42**	25	17	x	6.8

Хүн амын нас баралт 2014 онд 63-аар өсч нийт нас барсан хүмүүсийн 62,13 хувь нь эрэгтэйчүүд юм. 2014 онд нас барсан хүн амын 32,36 хувь 70-дээш насны хүмүүс, 17.79 хувь нь 60-69 насны, 17,31 хувь нь 50-59 насны, 10.67 хувь нь 40-49 насны хүмүүс, 3,88 хувийг 0-4 насны хүүхэд тус бүр эзлэв.

Гэрлэлт, цуцлалт

Аймгийн хэмжээнд 2014 онд 423 хос гэрлэлтээ бүртгүүлж, 59 хос гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 31 хүүхэд үрчлэгджээ.

Аймгийн хүн амын гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

Зураг. 17



2.Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүд

Аймгийн хэмжээнд 2014 онд 128 бүтэн өнчин, 997 хагас өнчин хүүхэд байгаа нь нийт хүүхдийн 0.41 хувь нь бүтэн өнчин, 3.21 хувь нь хагас өнчин хүүхэд эзэлжээ.

1.Эмзэг бүлгийн хүүхдийн тоо

	2012	2013	2014
Бүтэн өнчин	123	109	128
Хагас өнчин	1042	1018	997

2014 оны байдлаар бүтэн өнчин хүүхдийн 2,3 хувь нь 0-4 насны, 10,93 хувь нь 5-9 насны, 52,34 хувь нь 10-14 насны, 34,37 хувь нь 16-17 насны хүүхдүүд, хагас өнчин хүүхдийн 9.6 хувь нь 0-4 насны, 20.03 хувь нь 7-14 насны, 34.97 хувь нь 16-17 насны хүүхдүүд юм.

1. Хөгжлийн бэрхшээл

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн 2545 байгаа нь нийт хүн амын 2,82 хувийг эзлэв. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 1471 буюу 57,79 хувь нь эрэгтэйчүүд, 1074 буюу 42,21 хувь нь эмэгтэйчүүд юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зургаар харуулбал: Зураг 18.



2.Өрх толгойлсон эмэгтэйчүүд

Өрх толгойлсон гэр бүлгүй хүний тоо 2014 онд 3074 байгаа нь өмнөх оноос 6,23 хувиар буурлаа.

	2012	2013	2014
Өрх толгойлсон гэр бүлгүй хүний тоо	3867	3278	3074
үүнээс: -Аймгийн төвд	465	524	399
-Хөдөөд	3402	2754	2675

Өрх толгойлсон хүүхэдтэй гэр бүлгүй эрэгтэйчүүдийн тоо 2014 онд 908 байгаа нь

өмнөх оноос 2,37 хувиар буурч, харин өрх толгойлсон гэр бүлгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо 2014 онд 7,76 хувиар буурчээ.

Өрх толгойлсон гэр бүлгүй хүүхэдтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2 дахин их байгаагаас харахад эмэгтэйчүүд амьдралын хүнд ачааг үүрч явдгийг харууллаа.

Өрх толгойлсон гэр бүлгүй хүний тоог хүйс, ам бүлийн бүлийн тоогоор сумдаар үзүүлбэл:

Он	Өрх толгойлсон гэр бүлгүй **эрэгтэй** хүний тоо	үүнээс: Ам бүлийн тоогоор			Өрх толгойлсон гэр бүлгүй **эмэгтэй** хүний тоо	үүнээс: Ам бүлийн тоогоор		
		3 хүртэл	3-5	6 ба дээш		3 хүртэл	3--5	6 ба дээш
2014	908	713	159	63	2166	1350	697	119
2013	930	700	171	59	2348	1558	614	176
2012	1235	853	315	67	2632	1702	775	155

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо зургаар харуулбал:

Зураг19.



I. СУДАЛГАА

2000-2014 оны хоорондох хүн амын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

2000-2014 оны хоорондох хүн амын тоог хронологийн дунджын аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{\frac{y_1}{2} + y_2 + \ldots\ldots + y_{n-1} + \frac{y_n}{2}}{n-1} = \frac{1368115}{15} = 91207.67$$

2000-2014 оны хооронд хүн амын тоо нь дунджаар 91.2 мянга байна.

2000-2014 оны хүн амын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

Суурин хүн амын динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолвол:

Онууд	Суурин хүний тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд%	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2000	99268				
2001	95706	-3562	96.41	-3.59	957
2002	96716	1010	101.06	1.06	967
2003	92816	-3900	95.97	-4.03	928
2004	88627	-4189	95.49	-4.51	886
2005	88491	-136	99.85	-0.15	885
2006	88460	-31	99.96	-0.04	885
2007	88828	368	100.42	0.42	888
2008	88889	61	100.07	0.07	889
2009	87210	-1679	98.11	-1.89	872
2010	87909	699	100.80	0.80	879
2011	88277	368	100.42	0.42	883
2012	87410	-867	99.02	-0.98	874
2013	88399	989	101.13	1.13	884
2014	90049	1650	101.87	1.87	900

Дээрх хүснэгтээс харахад 2014 онд хүн амын тоо 2000 оныхоос 9219 хүнээр буюу 9.29 хувиар буурахад бууралтийн 1.0 хувьд 900 хүн ногдлоо.

2000 оноос хойших хүн амын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

$$K = \sqrt[15]{1*0.9641*1.0106*...*0.9902*0.8905*1.9071} = \overline{K} = 1 = \sqrt[15]{0.843176138} = 0.91.8246$$

буюу 91.82 % гарсан нь 2000 оноос хойш хүний тоо жилд дунджаар -1.9182 хувиар буурлаа.

Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

Суурин хүн амын динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:

Онууд	Суурин хүний тоо	Суурь абсолют цэвэр өсөлт (тоо)	Суурь өсөлтийн хурд 2000=100%	Суурь цэвэр өсөлтийн хурд %
2000	99268		100.00	
2001	95706	-3562	96.41	-3.59
2002	96716	-2552	97.43	-2.57
2003	92816	-6452	93.50	-6.50
2004	88627	-10641	89.28	-10.72
2005	88491	-10777	89.14	-10.86
2006	88460	-10808	89.11	-10.89
2007	88828	-10440	89.48	-10.52
2008	88889	-10379	89.54	-10.46
2009	87210	-12058	87.85	-12.15
2010	87909	-11359	88.56	-11.44
2011	88277	-10991	88.93	-11.07
2012	87410	-11858	88.05	-11.95
2013	88399	-10869	89.05	-10.95
2014	90049	-9219	90.71	-9.29

Динамик хандлагын шинжилгээ /прогнозчлол/.

Эдийн засгийн аливаа үзэгдэлийг динамикаар судлах үед түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол буюу динамик чиг хандлагыг тодорхойлох шаардлага тавигддаг. Төв аймгийн хүний тооны өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнчлэн дараагийн 5 жилийн прогноз боловсруулахын тулд динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлж тооцоо хийх аргыг ашиглаж болох юм. Ингэхдээ 2000-2014 оны хооронд динамик хандлагын шинжилгээг хийлээ. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга гэдэг нь судлагдаж байгаа түвшингүүдийг хугацаанаас хамаарсан функц гэж үзээд динамик эгнээний өгөгдсөн түвшингүүдийг бага хэлбэлзэл бүхий түвшингүүдээр солих арга юм.

Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх аргыг ашиглан 2000-2014 онуудад хүн амын төрөлт, шилжилт зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүй байсан бол хүн амын тоо ямар түвшинд хүрэх байсан бэ, мөн цаашид дээрхи хүчин зүйлүүд нөлөөлөхгүйгээр байвал 2015-2016 онуудад хэдэд хүрэхээр байна нь вэ гэдгийг гаргаж үзлээ. Бидний авч үзэж байгаа динамик эгнээг графикаар дүрсэлж үзэхэд дараахь хэлбэртэй байна.

Зураг 13.

2000 оноос хойшхи 15 жилийн хүн амын тооны бодит утга дээр тулгуурлан шулуун шугамын аргыг ашиглаж тэгшитгэсэн утгыг гаргая.

Тэгшитгэл нь $y_{(t)}=a+bt$ томъёогоор илэрхийлнэ. Үүнд:

t- хугацаа

a,в- тэгшитгэлийн параметрүүд

$$\begin{cases} na + b\sum t = \sum y \\ a\sum t + b\sum t^2 = \sum yt \end{cases}$$

Тэгшитгэлийн параметрүүдийг дараах систем тэгшитгэлээр бодох бөгөөд

Систем тэгшитгэлийн бодолтыг хялбарчилахын тулд $\sum t = 0$ байхаар хугацаанд t гэсэн код өгвөл системт тэгшитгэл

$$\begin{cases} na = \sum y \\ b\sum t^2 = \sum yt \end{cases}$$ болно.

Системт тэгшитгэлийг бодож гаргахын тулд дараахь тооцооллуудыг хийе.

Y_t- хүн амын тоо, t- хугацаа

Эндээс a=1357055/15=90470,33

b=-177348/280=-633,38 болж**,** y_t=90470,33-633,38t гэсэн динамик хандлагын тэгшитгэл гарлаа.

Уг тэгшитгэлийг ашиглан 2000-2014 онуудад ямар нэгэн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл байгаагүй бол хүн амын тоо хэдэд хүрэх байж вэ, цаашид 2015-2017 онуудад хэдэд хүрэх вэ гэсэн y_t утгыг гарган авахад доорхи байдалтай байна.

Хүснэгт 3.

	Y	T	t^2	y*t	y_t=a+bt
2000	99268	-7	49	-694876	94903.99
2001	95706	-6	36	-574236	94270.61
2002	96716	-5	25	-483580	93637.23
2003	92816	-4	16	-371264	93003.85
2004	88627	-3	9	-265881	92370.47
2005	88491	-2	4	-176982	91737.09
2006	88460	-1	1	-88460	91103.71
2007	88828	0	0	0	90470.33
2008	88889	1	1	88889	89836.95
2009	87210	2	4	174420	89203.57
2010	87909	3	9	263727	88570.19
2011	88277	4	16	353108	87936.81
2012	87410	5	25	437050	87303.43
2013	88399	6	36	530394	86670.05
2014	90049	7	49	630343	86036.67
Дүн	**1357055**	**0**	**280**	**-177348**	
2015		8		-	85403.29
2016		9		-	84769.91
2017		10			84136.53

Хүснэгт4

	Y	y_t=a+bt
2000	99268	94903.99
2001	95706	94270.61
2002	96716	93637.23
2003	92816	93003.85
2004	88627	92370.47
2005	88491	91737.09
2006	88460	91103.71
2007	88828	90470.33
2008	88889	89836.95
2009	87210	89203.57
2010	87909	88570.19
2011	88277	87936.81
2012	87410	87303.43
2013	88399	86670.05
2014	90449	86036.67
2015	-	85403.29
2016	-	84769.91
2017	-	84136.53

y- бодит утга буюу гүйцэтгэлээр гарсан хүн амын тоо

y_t - тэгшитгэлээр гарсан хүн амын тоо

Цикл хэлбэлзэлийн шинжилгээ

Динамик хандлагын шинжилгээг хийхдээ хэдийгээр цикл болон гэнэтийн хэлбэлзлийг динамик эгнээнийн бүрэлдэхүүнээс арилгаж математик тэгшитгэлд шилжүүлдэг боловч тухайн үзэгдэлийн цикл хэлбэлзэлийг судлах нь үзэгдлийн өнгөрсөн үеүдийн хөгжил өөрчлөлтийг илүү тодорхой судалж дүгнэлт гаргахад үр нөлөөтэй байдаг. Цикл хэлбэлзлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцвол

Онууд	Бодит утга	Тэгшитгэсэн утга	Хандлагын хувийн жин	Цикл үлдэгдлийн харьцангуй хэмжигдэхүүн
2000	99268	94904	95.60%	-4.40%
2001	95706	94271	98.50%	-1.50%
2002	96716	93637	96.82%	-3.18%
2003	92816	93004	100.20%	0.20%
2004	88627	92370	104.22%	4.22%
2005	88491	91737	103.67%	3.67%
2006	88460	91104	102.99%	2.99%
2007	88828	90470	101.85%	1.85%
2008	88889	89837	101.07%	1.07%
2009	87210	89204	102.29%	2.29%
2010	87909	88570	100.75%	0.75%
2011	88277	87937	99.61%	-0.39%
2012	87410	87303	99.88%	-0.12%
2013	88399	86670	98.04%	-1.96%
2014	90049	86037	95.54%	-4.46%

Сумдын суурин хүн ам 2000 оныг 2014 онтой харьцуулсан үзүүлэлт

Д/д	Сумдын нэр	Он		Харьцуулсан хувь	Жилийн дундаж өсөлтийн хувь
		2000	2014	2014/2000	2014/2000
1	Алтанбулаг	**3702**	3106	83.90	-1.25
2	Аргалант	**1988**	1616	81.29	-1.47
3	Архуст	**2008**	1254	62.45	-3.31
4	Батсүмбэр	**6537**	6787	103.82	0.27
5	Баян	**3193**	2063	64.61	-3.07
6	Баяндэлгэр	**2058**	1330	64.63	-3.07
7	Баянжаргалан	**1789**	1571	87.81	-0.92
8	Баянөнжүүл	**2503**	2086	83.34	-1.29
9	Баянхангай	**1710**	1379	80.64	-1.52
10	Баянцагаан	**2724**	1803	66.19	-2.90
11	Баянцогт	**2430**	1841	75.76	-1.96
12	Баянчандмань	**3458**	4099	118.54	1.22
13	Борнуур	**4206**	5059	120.28	1.33
14	Бүрэн	**3473**	3012	86.73	-1.01
15	Дэлгэрхаан	**2470**	1660	67.21	-2.80
16	Жаргалант	**5513**	6348	115.15	1.01
17	Заамар	**6342**	5407	85.26	-1.13
18	Лүн	**3697**	2652	71.73	-2.34
19	Менгэнморьт	**2569**	1991	77.50	-1.80
20	Өндөрширээт	**2265**	1921	84.81	-1.17
21	Сүмбэр	**1982**	1778	89.71	-0.77
22	Сэргэлэн	**2005**	1841	91.82	-0.61
23	Угтаал	**3534**	2640	74.70	-2.06
24	Цээл	**3671**	2480	67.56	-2.76
25	Эрдэнэ	**3110**	3862	124.18	1.56
26	Эрдэнэсант	**5494**	4369	79.52	-1.62
27	Зуунмод	**14837**	16094	108.47	0.58
	Дүн	99268	90049	90.71	-0.69

Зураг 20.



Мөн хүн амын тоо 2014 онд хэдэд хүрч болохыг прогноз хийж үзлээ

Хүснэгт 7.

	Бодит утга-у	**тэгшитгэлийн утга -y_t**	**$y-y_t$**	**$(y-y_t)^2$**
2000	99.268	94.903	4.365	19.053
2001	95.706	94.270	1.436	2.062
2002	96.716	93.637	3.079	9.480
2003	92.816	93.003	-0.187	0.035
2004	88.627	92.370	-3.743	14.010
2005	88.491	91.737	-3.246	10.537
2006	88.460	91.103	-2.643	6.985
2007	88.828	90.470	-1.642	2.696
2008	88.889	89.836	-0.947	0.897
2009	87.210	89.203	-1.993	3.972
2010	87.909	88.570	-0.661	0.437
2011	88.277	87.936	0.341	0.116
2012	87.410	87.303	0.107	0.011
2013	88.399	86.670	1.729	2.989
2014	90.049	86.036	4.013	16.104
Дүн				**89.386**

Үүний тулд доорхи томьёог ашиглана. $y \pm t_\alpha * \delta_y$ δ_y-хандлагын (трэндийн) квадрат дундаж хазайлт $\delta_y = \sqrt{\frac{\sum (y - y_t)^2}{n-1}} = \sqrt{\frac{89.386}{15-1}}$ 6.384714 =2.526799 t_α-k чөлөөний зэрэг бүхий Стьютендийн тархалт k=n-1=15-1=14, t(0.05,14)=2.144788596; $t_\alpha * \delta_y$ =2.144788596*2.526799=5.419; 2014 оны түвшин 85403,29+5.419=90822,29; 85403,29–5.419=79984,29 95.0 хувийн магадлалтайгаар 2014 оны түвшин 79984<$y_{прог}$<90822 байна. 2014 онд хүн амын тоо 79984-ээс 90822 хооронд байх ба энэ нь 95.0 хувийн магадлалтай гэсэн үг юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ.

Хүн ам, нийгмийн статистик мэдээ, тайлангуудын гаргалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд: Суурин хүн амын (ХА-3) тайлан, Хүн амын шилжилт хөдөлгөөний (ХА-2) тайлан, Хүн ам, өрхийн нийгмийн зарим үзүүлэлтийн (НС-1) тайлангуудын маягтын үзүүлэлт, зааварыг YCX-ноос баталж ирүүлсэн 2003 оны жилийн эцсээс эхлэн үндсэн нэгжүүдэд мөрдүүлэн ажиллаж жил бүр судалгааг хийж хэвшлээ.

Төв аймгийн хүн амын тоог сүүлийн 3 жилээр авч үзэхэд 2013 онд 1,12 хувиар, 2014 онд 1.84 хувиар өссөн байна. Хүн амын тоог бууруулахгүй байх нь аймгийн эдийн засаг, нийгмийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой тул үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, сурч, боловсрох, эрүүл мэндийн, соёлын болон төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай авах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж иргэдийн шилжин явах хөдөлгөөнийг аль болохоор сааруулж эерэг урсгал бий болгоход байнга анхаарч, энэ чиглэлийн бодлого хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Аймгийн хүн амын нягтшил 1.19 байгаа бөгөөд нийт өрх хүн амын 17.87 хувь нь аймгийн төвийн Зуунмод хотод оршин суудаг. Манай аймаг дундаж суурьшилтай аймгийн нэг хэвээр байна.

100 эмэгтэй тутамд ногдох эрэгтэйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд аажмаар өсч байгаа нь нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингээс өндөр байгааг харууллаа. Энэ үзүүлэлт 2012 онд 50.47, 2013 онд 50.96, 2014 онд 51.23, байгаа нь нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин илүү байгаа нь харагдлаа.

2014 онд хүн ам зүйн ачааллаас харахад 100 тэжээгчид ногдох тэжээлгэгч хүний тоо сүүлийн 3 жилд өссөөр байна.

Аймгийн хэмжээнд тэргэнцэртэй хүн 68, байнгын асаргаанд байдаг хөгжлийн

бэрхшээлтэй хүн 293, тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүн 2255, хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүн 391, хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 1983 байна.

Нас барсан хүмүүсийн 62.13 хувь нь эрэгтэйчүүд байгаагийн дотор ид хийж бүтээх насны буюу 20-49 насны эрэгтэйчүүдийн нас баралт өмнөх оноосоо 0.76 пунктээр буурлаа. Суурин хүн амын тоо 2000 оноос хойш жил бүр дунджаар 1.0 хувиар буурч байгаа нь:

- Улс орон зах зээлд шилжсэнээс хойш, ажлын байр багассан, амьжиргааны өртөг нэмэгдсэн зэрэг нөлөөллөөс хүн ам төв, суурин газар руу шилжих урсгал нэмэгдэж 2011-2014 онд 3.5-3.6 мянгад хүрч, 2014 онд шилжин явсан хүний тоо шилжин ирсэнээс 40.4 хувиар их байна.
- Хүн амын цэвэр өсөлт 2009 онд 1000 хүнд ногдох төрөлт 24, нас баралт 7, цэвэр өсөлт 18 байсан бол 2014 онд төрөлт 25, нас баралт 6.9, цэвэр өсөлт 18,3 болж буурч байгаа боловч хүн ам нэмэгдэхэд нөлөөлсөнгүй.
- Хүн ам ихтэй Зуунмодын 6 баг 1258-344, Батсүмбэрийн 4 баг 764-379, Жаргалантын 4 баг 698-230, Эрдэнэсантын 5 баг 413-187 өрхтэй байхад Баян сумын хөдөөний 2 баг 407-117, Баянцагаан сумын 5 баг 147-112, Бүрэн сумын 5 баг 209-107, Сэргэлэн сумын 5 баг 183-101, Цээл сумын 5 баг 172-114 өрхтэй юм.

Харин аймгийн хэмжээнд төрөлт өмнөх оноосоо 2014 онд 4.9 хувиар буурчээ. Хэрэглэгч та бүхэнд толилуулж буй энэхүү судалгаа танилцуулга, холбогдох тоо мэдээллийг аймаг, орон нутгийнхаа нийгмийн хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах болон шинжилгээ судалгааны ажилд өргөнөөр ашиглахыг хүсье.

Танилцуулгын болон статистикийн мэдээллийн талаар өөрийн санал хүсэлтээ бидний хаягаар ирүүлбэл талархан хүлээн авч хамтран ажиллах болно.

Хаяг: Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, өрөө 115
Утас: 70272275
70272136
Цахим хаяг. tuv@nso.mn ; tuv_sta@yahoo.com
Веб хуудас: www.tuv.nso.mn

Статистикийн хэлтсийн дарга Ж.Отгончулуун

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ /СУМДААР/

1. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд.
2. Сумдын өрхийн тоо, тэдгээрийн байршилын үзүүлэлтүүд
3. Сумдын суурин хүний тоо хүйсээр
4. Сумдын нийт хүн амд хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин
5. Сумдын нийт хүн амын насны ерөнхий бүтэц, хүн ам зүйн ачаалал
6. Сумдын нийт хүн амд өндөр настангуудын эзлэх хувь, өндөр настнуудын насны бүтцийн үзүүлэлтүүд
7. нийт өндөр настанд эмэгтэй өндөр настануудын эзлэх хувь, насны бүтцийн үзүүлэлтүүд
8. Хүн ам, өрхийн тоо багаар
9. Бүтэн өнчин хүүхдүүд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоо
10. Бүтэн өнчин хүүхдүүд насны бүлэг, хүйсээр
11. Хагас өнчин хүүхдийн тоог сумдаар
12. Хагас өнчин эрэгтэй хүүхдийн тоог сумдаар
13. Хагас өнчин эмэгтэй хүүхдийн тоог сумдаар
14. Гэр бүлгүй (16 хүртэл насны) хүүхэдтэй эх, эцгийн тоог сумдаар
15. Өрх толгойлсон гэр бүлгүй хүн ам бүлийн тоогоор, олон ам бүлтэй өрхүүдийн тоог сумдаар
16. Өрх толгойлсон гэр бүлгүй хүн, ам бүлийн тоог сумдаар
17. Өндөр настан ганц бие өрх, тэтгэвэр, тэтгэмж, тогтоогдоогүй өндөр настай хүний тоог сум, байршлаар
18. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо сумдаар
19. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
20. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс хөдөлмөрийн насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
21. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс харах эрхтний өөрчлөлтэй хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
22. Харах эрхтний өөрчлөлттэй хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум хүйс, шалтгаанаар
23. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар

24. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум хүйс, шалтгаанаар
25. Нийт хүн амд 15-49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин
26. Сумдын хүн амын ердийн хөдөлгөөний талаархи мэдээлэл
27. Хүн амын нийгмийн холбоотой үр дүнгийн үзүүлэлтүүд
28. Хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй хүний тоо
29. Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг хүний тоо
30. Тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
31. Хөгжлийн бэхшээлтэй хөдөлмөр эрхэлдэг хүний тоо
32. Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхэлдэггүй хүний тоо

Мэдээллийн эх үүсвэр:

- Суурин хүн амын 2011-2014 оны жилийн тайлан /ХА-3/
- Хүн амын ердийн хөдөлгөөний 2011-2014 оны жилийн тайлан / ХА-1/
- Өрх хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн 2011-2014 оны жилийн тайлан /НС-1, НЗҮ-1/
- Аймгийн статистикийн бюллетень танилцуулга 2014 он

Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд.	*Хэмжих нэгж*	2014 оны				
		Аймгийн дундаж	**Хамгийн**			
			их		бага	
Хүн амын тоогоор	хүн	**3335**	**Зуунмод**	**16094**	**Архуст**	**1254**
			Батсүмбэр	6787	Баяндэлгэр	1330
			Жаргалант	6348	Баянхангай	1379
			Заамар	5407	Баянжаргалан	1571
			Борнуур	5059	Аргалант	1616
Хүн амын нягтрал	хүн	**1.2**	**Зуунмод**	**839.10**	**Баянцагаан**	**0.20**
			Баянчандмань	6.70	Мөнгөнморьт	0.30
			Сүмбэр	5.00	Эрдэнэ	0.48
			Борнуур	4.40	Сэргэлэн	0.48
			Жаргалант	3.40	Алтанбулаг	0.55
Өрхийн тоогоор	өрх	**1039**	**Зуунмод**	**4711**	**Архуст**	**410**
			Батсүмбэр	2062	Баянхангай	464
			Жаргалант	1955	Баянжаргалан	494
			Заамар	1593	Баяндэлгэр	534
			Борнуур	1542	Сүмбэр	532
Өрхийн дундаж ам бүл	хүн	**3.3**	**Бүрэн**	**3.6**	**Баяндэлгэр**	**2.5**
			Батсүмбэр	3.3	Мөнгөнморьт	2.7
			Цээл	3.3	Сэргэлэн	2.8
			Эрдэнэсант	3.3	Аргалант	2.8
			Зуунмод	3.3	Баянцагаан	2.9
Хүйсийн харьцаа 100 эмэгтэйд ноогдох эрэгтэй	хүн	**105.1**	**Баянцогт**	**124.0**	**Зуунмод**	**95.9**
			Мөнгөнморьт	120.0	Баян	96.0
			Баяндэлгэр	120.0	Борнуур	99.9
			Аргалант	117.0	Бүрэн	101.6
			Баян-Өнжүүл	116.0	Жаргалант	102.5
Хүн ам зүйн ачаалал	хувь	**47.9**	**Дэлгэрхаан**	**58.7**	**Баяндэлгэр**	**41.6**
			Бүрэн	58.7	Аргалант	42.8
			Угтаалцайдам	56.2	Баянцагаан	43.1
			Батсүмбэр	53.3	Мөнгөнморьт	43.6
			Баян	50.0	Зуунмод	44.6
Өндөр настны тоогоор	хүн	**388**	**Зуунмод**	**2011**	**Архуст**	**147**
			Батсүмбэр	908	Баянхангай	155
			Жаргалант	671	Баянжаргалан	166
			Борнуур	583	Сүмбэр	189
			Эрдэнэсант	587	Баяндэлгэр	196
Өндөр настан эмэгтэйчүүдийн тоогоор	хүн	**207**	**Зуунмод**	**1165**	**Архуст**	70
			Батсүмбэр	471	Баянхангай	80
			Жаргалант	358	Баянөнжүүл	83
			Борнуур	325	Баяндэлгэр	89
			Эрдэнэсант	261	Сүмбэр	94
1000 хүнд ногдох төрөлтийн тоогоор	хүн	**25.2**	**Заамар**	**31.3**	**Баяндэлгэр**	**18.5**
			Дэлгэрхаан	30.7	Мөнгөнморьт	18.7
			Цээл	29.7	Баянхангай	20.1
			Баянцогт	29.5	Аргалант	20.7
			Баян	27.1	Архуст	20.9

Үзүүлэлтүүд.	*Хэмжих нэгж*	2014 оны				
		Аймгийн дундаж	**Хамгийн**			
			их		бага	
1000 хүнд ногдох нас баралтын тоогоор	хүн	**6.9**	**Батсүмбэр**	**11.9**	**Лүн**	**4.2**
			Эрдэнэ	8.7	Алтанбулаг	4.3
			Баян	8.4	Борнуур	4.8
			Цээл	8.4	Өндөрширээт	4.8
			Зуунмод	8.2	Заамар	4.9
1000 хүнд ногдох цэвэр өсөлт тоогоор	хүн	**18.3**	**Заамар**	**26.4**	**Баяндэлгэр**	**9.8**
			Баян-Өнжүүл	25.4	Мөнгөнморьт	12.3
			Дэлгэрхаан	23.5	Батсүмбэр	13.4
			Өндөрширээт	22.9	Баянхангай	14.4
			Баянцогт	21.9	Архуст	14.5
10000 хүнд ногдох эмнэлгийн ор	ор	**53.3**	**Зуунмод**	**144.1**	**Батсүмбэр**	**22.1**
			Аргалант	56.4	Заамар	28.1
			Баянхангай	50.3	Эрдэнэ	30.3
			Архуст	48.2	Баянчандмань	30.4
			Дэлгэрхаан	48.1	Угтаалцайдам	31
10000 хүнд ногдох хүний их эмч	хүн	**18**	**Зуунмод**	**65.0**	**Баян-Өнжүүл**	**4.8**
			Эрдэнэсант	13.5	Мөнгөнморьт	4.9
			Цээл	12.0	Сэргэлэн	5.2
			Аргалант	12.5	Өндөрширээт	5.3
			Лүн	11.4	Эрдэнэ	5.3
10000 хүнд ногдох эмнэлгийн дунд мэргэжилтэн	хүн	**53.7**	**Зуунмод**	**119.9**	**Батсүмбэр**	**19.2**
			Архуст	72.3	Жаргалант	20.6
			Баяндэлгэр	67.9	Заамар	26.2
			Баянжаргалан	64.5	Алтанбулаг	26.2
			Сүмбэр	62.5	Борнуур	26.2
10000 хүнд ногдох Е.Б.Сургуульд суралцагсад	хүн	**1125**	**Заамар**	**1834.8**	**Сэргэлэн**	**238.5**
			Угтаалцайдам	1741.8	Баянцагаан	**432.9**
			Цээл	1708.1	Баян-Өнжүүл	488.7
			Жаргалант	1537.5	Баяндэлгэр	754.4
			Сүмбэр	1512.2	Дэлгэрхаан	878.7
10000 хүнд ногдох үзвэр үзэгчид	хүн	**3921.9**	**Зуунмод**	**12180.0**	**Эрдэнэ**	**205.3**
			Угтаалцайдам	9982.6	Заамар	310.7
			Өндөрширээт	6180.1	Баян-Өнжүүл	407.3
			Эрдэнэсант	5806.3	Борнуур	461.8
			Баяндэлгэр	4677.5	Дэлгэрхаан	493.5

Сумдын өрхийн тоо, тэдгээрийн байршлыг үзүүлбэл:

	Нийт өрхийн тоо		үүнээс				Өрхийн дундаж ам бүл	Аймгийн дүнд эзлэх хувийн жин
			Хот суурин, сумын төв		Хөдөөд			
	Эцэст		тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь		
	2013 оны	**2014 оны**						
1.Алтанбулаг	**958**	972	298	30.66	674	69.34	3.20	3.46
2.Аргалант	**530**	576	304	52.78	272	47.22	2.81	2.05
3.Архуст	**405**	410	179	43.66	231	190.00	3.06	1.46
4.Батсүмбэр	**1994**	2062	764	37.05	1298	62.95	3.29	7.35
5.Баян	**630**	654	449	68.65	205	31.35	3.15	2.33
6.Баяндэлгэр	**540**	534	110	20.60	424	79.40	2.49	1.90
7.Баянжаргалан	**486**	494	185	37.45	309	62.55	3.18	1.76
8.Баян-Өнжүүл	**607**	643	143	22.24	500	77.76	3.24	2.29
9.Баянхангай	**462**	464	187	40.30	277	59.70	2.97	1.65
10.Баянцагаан	**595**	612	205	33.50	407	66.50	2.95	2.18
11.Баянцогт	**644**	651	271	41.63	380	58.37	2.83	2.32
12.Баянчандмань	**1196**	1245	967	77.67	278	22.33	3.29	4.44
13.Борнуур	**1495**	1542	756	49.03	786	50.97	3.28	5.49
14.Бүрэн	**847**	848	270	31.84	578	68.16	3.55	3.02
15.Дэлгэрхаан	**499**	504	280	55.56	224	44.44	3.29	1.80
16.Жаргалант	**1880**	1955	1384	70.79	571	29.21	3.25	6.97
17.Заамар	**1561**	1593	452	28.37	1141	71.63	3.39	5.68
18.Лүн	**789**	791	318	40.20	473	59.80	3.35	2.82
19.Мөнгөнморьт	**723**	739	309	41.81	430	58.19	2.69	2.63
20.Өндөрширээт	**598**	605	110	18.18	495	81.82	3.18	2.16
21.Сүмбэр	**545**	532	421	79.14	111	20.86	3.34	1.90
22.Сэргэлэн	**672**	670	187	27.91	483	72.09	2.75	2.39
23.Угтаал	**765**	798	463	58.02	335	41.98	3.31	2.84
24.Цээл	**725**	745	474	63.62	271	36.38	3.33	2.65
25.Эрдэнэ	**1278**	1287	540	41.96	747	58.04	3.00	4.59
26.Эрдэнэсант	**1307**	1311	549	41.88	762	58.12	3.33	4.67
27.Зуунмод	**4546**	4826	4711	6.00	115	2.38	3.33	17.20
Аймгийн дүн	**27277**	**28063**	**15286**	**54.47**	**12777**	**45.53**	**3.26**	100.0
Бүсүүдийн дүн Төвийн бүс	7378	7723	5544	71.79	2179	28.21	3.26	27.52
Хойт бүс	8284	8563	4867	56.84	3696	43.16	3.32	30.51
Баруун бүс	7553	7659	3103	40.51	4556	59.49	3.38	27.29
Зүүн бүс	4062	4118	1772	43.03	2346	56.97	2.95	14.67
2013 он		**27277**	**15138**	**55.50**	**12139**	**44.50**	**3.26**	
2012 он		**26779**	**14530**	**54.26**	**12249**	**45.74**	**3.26**	
2011 он		26901	13836	51.43	13065	48.57	3.28	

Сумдын хүн амын тоо, тэдгээрийн байршлыг үзүүлбэл:

	Суурин хүн амын тоо			үүнээс				Аймгийн дүнд эзлэх хувийн жин
				хот, суурин, сумын төв		хөдөөд		
	2012 оны эцэст	**2013 оны эцэст**	**2014 оны эцэст**	тоо	хувийн жин	тоо	хувийн жин	
1.Алтанбулаг	3006	**3084**	**3106**	891	28.69	2215	71.31	3.45
2.Аргалант	1566	**1561**	**1616**	776	48.02	840	51.98	1.79
3.Архуст	1238	**1280**	**1254**	499	39.79	755	60.21	1.39
4.Батсүмбэр	6772	**6823**	**6787**	2704	39.84	4083	60.16	7.54
5.Баян	2024	**1996**	**2063**	1281	62.09	782	37.91	2.29
6.Баяндэлгэр	1345	**1386**	**1330**	334	25.11	996	74.89	1.48
7.Баянжаргалан	1558	**1570**	**1571**	550	35.01	1021	64.99	1.74
8.Баянөнжүүл	2031	**2011**	**2086**	782	37.49	1304	62.51	2.32
9.Баянхангай	1404	**1401**	**1379**	518	37.56	861	62.44	1.53
10.Баянцагаан	1712	**1715**	**1803**	645	35.77	1158	64.23	2.00
11.Баянцогт	1812	**1812**	**1841**	811	44.05	1030	55.95	2.04
12.Баянчандмань	3603	**3823**	**4099**	3336	81.39	763	18.61	4.55
13.Борнуур	4825	**5046**	**5059**	2666	52.70	2393	47.30	5.62
14.Бүрэн	3029	**2991**	**3012**	808	26.83	2204	73.17	3.34
15.Дэлгэрхаан	1339	**1565**	**1660**	891	53.67	769	46.33	1.84
16.Жаргалант	6306	**6314**	**6348**	4521	71.22	1827	28.78	7.05
17.Заамар	5133	**5334**	**5407**	1543	28.54	3864	71.46	6.00
18.Лүн	2586	**2591**	**2652**	1035	39.03	1617	60.97	2.95
19.Мөнгөнморьт	2065	**1983**	**1991**	914	45.91	1077	54.09	2.21
20.Өндөрширээт	1844	**1869**	**1921**	336	17.49	1585	82.51	2.13
21.Сүмбэр	1819	**1844**	**1778**	1344	75.59	434	24.41	1.97
22.Сэргэлэн	1846	**1866**	**1841**	520	28.25	1321	71.75	2.04
23.Угтаал	2583	**2594**	**2640**	1508	57.12	1132	42.88	2.93
24.Цээл	2509	**2466**	**2480**	1559	62.86	921	37.14	2.75
25.Эрдэнэ	3762	**3696**	**3862**	1637	42.39	2225	57.61	4.29
26.Эрдэнэсант	4420	**4381**	**4369**	1769	40.49	2600	59.51	4.85
27.Зуунмод	15273	**15273**	**16094**	15702	97.56	392		17.87
Аймгийн дүн	**87410**	**88275**	**90049**	**49880**	**55.39**	**40169**	**44.61**	100.0
Бүсүүдийн дүн Төвийн бүс	23868	23949	24930	18540	**74.37**	6390	**25.63**	27.68
Хойт бүс	26703	27223	27528	16158	**58.70**	11370	**41.30**	30.57
Баруун бүс	24847	25192	25520	9967	**39.06**	15553	**60.94**	28.34
Зүүн бүс	11992	11911	12071	5215	**43.20**	6856	**56.80**	13.40
2013 он			88399	49384	**55.86**	39015	**44.14**	
2012 он			87410	48143	**55.08**	39267	**44.92**	
2011 он			88277	45710	**51.78**	42567	**48.22**	

Сумдын суурин хүний тоо хүйсээр:

	Нийт хүний тоо	үүнээс				Хүйсийн харьцаа (100 эмэгтэйд)
		Эрэгтэй		Эмэгтэй		
		тоо	хувийн жин	тоо	хувийн жин	
1.Алтанбулаг	3106	1623	52.25	1483	47.75	109.44
2.Аргалант	1616	871	53.90	745	46.10	116.91
3.Архуст	1254	652	51.99	602	48.01	108.31
4.Батсүмбэр	6787	3472	51.16	3315	48.84	104.74
5.Баян	2063	1012	49.05	1051	50.95	96.29
6.Баяндэлгэр	1330	727	54.66	603	45.34	120.56
7.Баянжаргалан	1571	807	51.37	764	48.63	105.63
8.Баян-Өнжүүл	2086	1119	53.64	967	46.36	115.72
9.Баянхангай	1379	725	52.57	654	47.43	110.86
10.Баянцагаан	1803	927	51.41	876	48.59	105.82
11.Баянцогт	1841	1019	55.35	822	44.65	123.97
12.Баянчандмань	4099	2173	53.01	1926	46.99	112.82
13.Борнуур	5059	2528	49.97	2531	50.03	99.88
14.Бүрэн	3012	1518	50.40	1494	49.60	101.61
15.Дэлгэрхаан	1660	850	51.20	810	48.80	104.94
16.Жаргалант	6348	3214	50.63	3134	49.37	102.55
17.Заамар	5407	2779	51.40	2628	48.60	105.75
18.Лүн	2652	1353	51.02	1299	48.98	104.16
19.Мөнгөнморьт	1991	1088	54.65	903	45.35	120.49
20.Өндөрширээт	1921	998	51.95	923	48.05	108.13
21.Сүмбэр	1778	938	52.76	840	47.24	111.67
22.Сэргэлэн	1841	982	53.34	859	46.66	114.32
23.Угтаал	2640	1344	50.91	1296	49.09	103.70
24.Цээл	2480	1268	51.13	1212	48.87	104.62
25.Эрдэнэ	3862	2026	52.46	1836	47.54	110.35
26.Эрдэнэсант	4369	2245	51.38	2124	48.62	105.70
27.Зуунмод	16094	7878	48.95	8216	51.05	95.89
Аймгийн дүн	**90049**	**46136**	**51.23**	**43913**	48.77	105.06
Б үс- Төвийн бүс	24930	12529	50.26	12401	49.74	101.03
үүд- Хойт бүс	27528	14215	51.64	13313	48.36	106.78
ийн Баруун бүс	25520	13080	51.25	12440	48.75	105.14
дүн Зүүн бүс	12071	6312	52.29	5759	47.71	109.60
2013 оны эцэст	88399	45046	50.96	40353	45.65	111.63
2012 оны эцэст	87410	44556	50.97	42854	49.03	103.32
2011 оны эцэст	88277	44860	50.82	43417	49.18	103.32

Сумдын нийт хүн амд хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин .

	Нийт хүн ам	0-7 насны		0 -15 насны		16 - 28 насны		0- 34 насны	
		тоо	хувийн жин	тоо	хувийн жин	тоо	хувийн жин	тоо	хувийн жин
1.Алтанбулаг	3106	492	15.84	841	27.08	783	25.21	1915	61.65
2.Аргалант	1616	277	17.14	451	27.91	386	23.89	981	60.71
3.Архуст	1254	228	18.18	364	29.03	317	25.28	786	62.68
4.Батсүмбэр	6787	1205	17.75	2079	30.63	1467	21.61	4111	60.57
5.Баян	2063	372	18.03	636	30.83	445	21.57	1262	61.17
6.Баяндэлгэр	1330	207	15.56	342	25.71	256	19.25	733	55.11
7.Баянжаргалан	1571	285	18.14	466	29.66	398	25.33	1030	65.56
8.Баянөнжүүл	2086	340	16.30	613	29.39	455	21.81	1324	63.47
9.Баянхангай	1379	266	19.29	430	31.18	316	22.92	897	65.05
10.Баянцагаан	1803	272	15.09	480	26.62	375	20.80	1046	58.01
11.Баянцогт	1841	311	16.89	513	27.87	454	24.66	1121	60.89
